

**Монголын эрх зүйн тогтолцоонд олон улсын заншлын
хэм хэмжээг хүлээн зөвшөөрөх онол ба практикийн асуудал**

**Theoretical and Practical Issues on Recognition of
International Customary Law in Mongolian Legal System**

Мягмарын Уянга

Хууль зүйн ухааны доктор (Ph.D.).

*Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор*

Улаанбаатар, Монгол Улс

uyanga_m@num.edu.mn



[Товч утга]

Энэхүү өгүүлэл нь олон улсын заншлын хэм хэмжээг Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд хэрхэн хүлээн зөвшөөрч, хэрэглэх боломжтой талаар онол, практикийн үүднээс судалсан. Өгүүллийн зорилго нь Монголын эрх зүйн тогтолцоон дахь олон улсын заншлын хэм хэмжээний байр суурийг тодорхойлж, дотоодын хууль тогтоомжид тусгах шаардлагыг үнэлэхэд оршино. Судалгаагаар Монгол Улсад олон улсын заншлыг хэрэглэх тодорхой зохицуулалт дутмаг ч, Иргэний болон Арбитрын тухай хуульд заншлын хэм хэмжээг хэрэглэх боломжийг нээсэн заалтууд байгааг тогтоосон. Иймд олон улсын заншлыг эрх зүйн хувьд тодорхойлж, үндэсний хууль тогтоомжид тусгах шаардлагатай байна.

[Түлхүүр үг]

Олон улсын заншил, олон улсын эрх зүй, Үндсэн хууль, эрх зүйн эх сурвалж, шүүхэд олон улсын заншил хэрэглэх, эдийн засгийн эрх зүй, татвар, хөрөнгө оруулалт, худалдаа, шүүх, эдийн засгийн харилцаа.

1. Танилцуулга

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд олон улсын гэрээг Монгол Улсад хэрэглэх үндэс суурийг тогтоож өгсөн боловч дотоодын эрх зүйн тогтолцоо дахь олон улсын заншлын талаар зохицуулаагүй байна. Олон улсын харилцааг зохицуулахад олон улсын заншлын хэм хэмжээ ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд НҮБ-ын Олон улсын шүүхийн дүрмийн 38 дугаар зүйлд зааснаар¹ олон улсын заншил нь олон улсын эрх зүйн үндсэн эх сурвалжийн нэг юм. Олон улсын заншил нь олон улсын гэрээний адил улс хоорондын харилцааг зохицуулах, олон улсын эрх зүйн хэм хэмжээг тогтооход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Гадаадын зарим улс Үндсэн хуульдаа олон улсын гэрээг дагаж мөрдөх үндэс суурийг тогтоохын зэрэгцээ олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх талаар зохицуулсан байдаг нь дотоодын эрх зүйд заншлын хэм хэмжээний гүйцэтгэх үүрэгт өндөр ач холбогдол өгч байгаагийн илэрхийлэл юм. Жишээ нь Япон улсын Үндсэн хуулийн 98 дугаар зүйлд “олон улсын гэрээ болон бусад хэм хэмжээг сахин биелүүлнэ”², ХБНГУ-ын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд³ “олон улсын эрх зүйн үндсэн хэм хэмжээ нь холбооны эрх зүйн тогтолцооны нэг хэсэг байна” гэж тус тус заасан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан гадаад бодлого хэрэгжүүлнэ”⁴ гэж зааснаас өөр олон улсын заншилд хамаарах зохицуулалт агуулагдаагүй.

Олон улсын худалдаа хөгжиж, эдийн засгийн харилцаанд олон улсын жишиг стандарт хэм хэмжээг ашиглах байдал нэмэгдэх болсноор дотоодын харилцааг зохицуулах, маргаан шийдвэрлэхэд олон улсын заншлын хэм хэмжээ чухал үүрэг гүйцэтгэх болоод байна. Хэдий олон улсын харилцааг зохицуулахад олон улсын гэрээ чухал үүрэг гүйцэтгэдэг ч бүхий л улс хоорондын асуудлаар олон улсын гэрээ байгуулагдаагүй тул тэрхүү хоосон орон зайг “нөхөхөд” олон улсын заншил ихээхэн үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, олон улсын худалдаа, татварын тооцоо, бүртгэл, банкны харилцаанд мөн дотоодын шүүх, арбитрын шүүхэд олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх практик

¹ НҮБ-ын Олон улсын шүүхийн дүрэм (1945), 38 дугаар зүйл.

² <http://www.japaneselawtranslation.go.jp/law/>, (Сүүлд үзсэн: 2026.03.06).

³ <https://www.bundesregierung.de/breg-en/chancellor/basic-law-470510>, (Сүүлд үзсэн: 2026.03.06).

⁴ Монгол Улсын Үндсэн хууль (1992), 10 дугаар зүйл 10.1, *Төрийн мэдээлэл, тусгай дугаар 1*, (Улаанбаатар: 1992).

тогтоод удаж байна. Жишээ нь улс хооронд бараа худалдах, худалдан авах болон тээврийн харилцаанд Инкотермсийн заншлын хэм хэмжээ, татварын тооцоо бүртгэлд Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын байгууллагаас⁵ (OECD) гаргасан зөвлөмж, хэм хэмжээг хэрэглээд олон жил болж байна.

Энэхүү өгүүлэлд олон улсын эрх зүйн үндсэн эх сурвалж болох олон улсын заншлын хэм хэмжээ, түүний онолын үндэслэл, дотоодын эрх зүйн тогтолцоонд гүйцэтгэх үүрэг, зохицуулалт, цаашдын чиг хандлагыг авч үзэхийг зорьлоо. Эхний хэсэгт олон улсын эрх зүйн үндсэн эх сурвалж болох олон улсын заншлын хэм хэмжээний хэлбэр, илэрхийлэгдэх эх сурвалжийн талаар, хоёр дахь хэсэгт нь дотоодын эрх зүйн тогтолцоонд гүйцэтгэх үүрэг, цаашдын чиг хандлагыг авч үзсэн.

2. Олон улсын заншлын хэлбэр, илэрхийлэгдэх эх сурвалж

Олон улсын эрх зүйн эх сурвалж нь дотоодын эрх зүйгээс ялгаатай нь улс хоорондын харилцан зөвшилцлийн үндсэн дээр бий болж, сайн дурын үндсэн дээр биелүүлэгддэг онцлогтой. Олон улсын эрх зүйн үндсэн эх сурвалж гэдэгт олон улсын гэрээ ба олон улсын заншил гэж заасан байдаг. Олон улсын заншил нь олон улсын гэрээтэй адил заавал дагаж мөрдөгдөх шинжтэй байдгаар дотоодын заншлын хэм хэмжээнээс ялгаатай юм. Эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудад заншлын хэм хэмжээ нь илүү туслах шинжтэй тул шүүхэд уг эх сурвалжийг хэрэглэхэд тусгайлан хуулиар зохицуулах шаардлага үүсдэг. Хью Тирлвэй нь олон улсын заншлын хэм хэмжээний заавал дагаж мөрдөгдөх ёстой шинжийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн гэжээ⁶.

Олон улсын гэрээний хүчин чадал болон гэрээний хэлбэр, байгуулах үе шатыг гэрээний “хууль” хэмээн нэрлэгддэг 1969 оны Улс хоорондын олон улсын гэрээний эрх зүйн тухай Конвенцид⁷ зохицуулсан бол олон улсын заншлын хэлбэр, хүчин төгөлдөр болох нөхцөл, бий болох үе шатын талаар зохицуулсан эрх зүйн эх сурвалж төдийлөн байхгүй бөгөөд заншлын хууль зүйн хүчин чадлыг илүү эрдэмтэн судлаачдын бүтээл, шүүхийн прецедентээр үнэлж тогтоосон байв.

Олон улсын гэрээний хэлбэр, агуулга, хүчин төгөлдөр

⁵ Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын байгууллага (OECD), Татвар, хөрөнгө оруулалт, даатгалын салбарын бодлого, зохицуулалтын зөвлөмж.

⁶ Malcolm D. Evans (Ed.), *International Law*, (Oxford: Oxford University Press, 2003), 124.

⁷ *Улс хоорондын олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенц* (1969), Төрийн мэдээлэл, тусгай дугаар 2, (Улаанбаатар: 1988).

байдлын талаар маргаан гардаг ч⁸ заншлын хэм хэмжээний талаар гардаг маргааныг бодоход харьцангуй цөөн юм. Олон улсын заншлын хэм хэмжээний талаар маргаан нь түүний хэлбэр, хүлээн зөвшөөрөх процесс, илэрхийлэгдэх эх сурвалж нь олон улсын гэрээтэй харьцуулахад тодорхой биш байдалтай холбоотой. Олон улсын заншлын талаар хэд хэдэн асуудал бөгөөд эдгээр асуудлыг тодорхойлсноор олон улсын заншил гэдэгт юуг ойлгох болон үндэсний хэмжээнд хэрэглэх талаасаа практик ач холбогдолтой юм.

Олон улсын заншлын элемент, бүрдэл хэсэг

Уламжлалт олон улсын эрх зүйгээр олон улсын заншил хэмээн тооцогдоход улс орнуудын практикт удаан хугацаанд давтагдсан байх, хоёр дахь нь эрх зүйн шинжтэй болсон буюу *opinion juris sive necessitates* гэсэн хоёр элементийг агуулсан байх шаардлагыг тавьдаг⁹. Энэ хоёр элемент хоёулаа байх шаардлагагүй, зөвхөн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн болон давтагдсан үйлдэл байх нь хангалттай гэж үздэг судлаачид ч байж ирсэн. Тэгвэл энэ маргааныг шийдвэрлэхэд олон улсын шүүхийн дүгнэлт ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Жишээ нь НҮБ-ын Олон улсын шүүх 1969 онд *Хойд Далайн эх газрын хормойн хэргийг* хянан шийдвэрлэх явцдаа улс орнуудын давтагдсан практик нь нийтээр хүлээн зөвшөөрөгдөж заавал сахин биелүүлэгдэх шинжтэй болохын тулд эрх зүйн шинжтэй болох хэрэгтэй гэсэн дүгнэлт гаргаж прецедент тогтоосон юм¹⁰. Эрдэмтэн судлаач, олон улсын эрх зүйчдийн олон жил маргалдаж ирсэн асуудлаар НҮБ-ын шүүхээс дүгнэлт гаргаж олон улсын заншил хэмээн хүлээн зөвшөөрөгдөхөд улс орнуудын давтагдсан практик нь эрх зүйн хэм хэмжээ буюу нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой болсон юм.

Олон улсын заншлын хэм хэмжээний хэлбэр

Олон улсын заншилтай холбоотой дараагийн асуудал нь олон улсын заншлын эхний элементтэй холбоотой бөгөөд улс орнуудын практик гэдэгт юуг ойлгох талаар асуудал юм¹¹. Өөрөөр хэлбэл олон улсын заншил илэрхийлэгдэх хэлбэр нь ямар байх ёстой талаар судлаач, хуульчид нэгдсэн байр суурьтай болж чадаагүй байна. Нэгдсэн Үндэстний байгууллага байгуулагдахаас өмнө олон улсын заншил гэдэгт бичигдээгүй бөгөөд харилцан хүлээн зөвшөөрсөн нийтээр дагаж мөрдөгдөх хэм хэмжээ гэж үздэг байсан¹². Дипломат

⁸ Malcolm D. Evans (Ed.), 120-121.

⁹ *Мөн тэнд.*

¹⁰ *North Sea Continental Shelf (Federal Republic of Germany v. Denmark; Federal Republic of Germany v. Netherlands)*, Judgment, I.C.J. Reports 1969, 3.

¹¹ David P. Fidler, "International Law and Infectious Diseases", *Evidence of Customary Law*, 201; Ian Brownlie, *Principles of Public International Law*.

¹² Joel P. Trachtman, "The Obsolescence of International Customary Law", *SSRN Research Database*, 2014.

төлөөлөгчийн халдашгүй дархан эрх, нээлттэй далайд бүх улс зорчих эрхтэй байх, эргийн улс нь далайг ашиглах давуу эрхтэй байх зэрэг нь заншлын хэм хэмжээний жишээ юм. Эдгээр нь улс орнуудын практикт тогтсон, бичигдээгүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ байсан.

Олон улсын эрх зүйн зохицуулалтын хүрээ тэлж нэмэгдэхийн хирээр улс орнууд өөрийн тогтсон практикаа бичгээр баталгаажуулж, түүнийг баримтжуулах болсон юм. Олон улсын гэрээ байгуулагдсан байгаа нь өөрөө олон улсын заншил тогтсоны нэг илэрхийлэл мөн ч гэж үздэг. Мөн хуульчийн дүгнэлт, олон улсын байгууллагын тогтоол, шийдвэр ба бусад зөвлөмжийн шинжтэй баримт бичгийг олон улсын заншил хэмээн хүлээн зөвшөөрөх хандлага бий болж байна¹³. Олон улсын арбитраг хэрэг хянан шийдвэрлэх явцдаа олон улсын зөвлөмжийн шинжтэй баримт бичгийг заншлын хэм хэмжээ болгох хэрэглэх практик түгээн дэлгэрсэн юм¹⁴. Тэгэхээр уламжлалт бичигдээгүй гэх ойлголтоос гарч өнөө үед олон улсын заншил нь бичигдсэн хэлбэртэй болж олон улсын хэмжээнд олон эрх зүйн баримт бичигт агуулагдах болжээ. Тухайлбал, олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг ИНКОТЕРМС-ийн худалдааны нөхцөлүүд¹⁵ ба Эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд (OECD) боловсруулсан загвар аргачлал, тооцооллын үндэс, Банкны олон улсын Базелийн холбооноос боловсруулсан журмыг улсын захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүд ихээхэн хэрэглэдэг болжээ. Мөн Олон улсын байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг зарим улсын дотоодын шүүхэд хэрэглэж, олон улсын заншлыг маргаан шийдвэрлэж шийдвэрийн үндэслэл болгосон байв. Олон улсын хөрөнгө оруулалтын талаар улс хоорондын хоёр талт 2000 гаруй гэрээ байгаа ч нарийн зохицуулалт бүрэн хийгдээгүй тул энэ салбарт ч олон улсын заншлын хэм хэмжээ чухал үүрэг гүйцэтгэсээр байгаа¹⁶.

НҮБ-ын Олон улсын шүүхийн практикт мөн олон улсын заншлын хэм хэмжээг тогтооход ихээхэн үүрэг гүйцэтгэж ирсэн. НҮБ-ын Шүүхийн Дүрмийн 38 дугаар зүйлд «Шүүх маргааныг хянан шийдвэрлэх болон дүгнэлт гаргахдаа эрдэмтдийн номлол буюу *opinio juris* -ийг хэрэглэнэ» гэж заасан байдаг. НҮБ-ын Олон улсын шүүх ба дотоодын зарим шүүх нь маргаан хянан шийдвэрлэхдээ олон улсын гэрээний ба дотоодын эрх зүйн зохицуулалт байхгүй нөхцөлд ямар

¹³ Oscar Schachter, “International Law in Theory and Practice”, *Recueil des Cours*, 178 (V), 1982, 111-121.

¹⁴ ИНКОТЕРМС болон УНИДРУА-ийн зарчмыг Олон улсын арбитраг хэрэглэж байгаа тохиолдол олон.

¹⁵ International Chamber of Commerce, *Incoterms 2020 Rules*, (Paris: ICC, 2020).

¹⁶ Moshe Hirsch, “Sources of International Investment Law”, *International Law Forum*, (Research Paper 05-11), The Hebrew University of Israel, 2011.

хэм хэмжээг хэрэглэх талаар асуудалтай тулгарч эрдэмтдийн номлол, дотоодын эрх зүйн хэм хэмжээ, олон улсын байгууллагын тогтоол шийдвэрийг судлан авч үзэж, эдгээрийг эшлэж заншлын хэм хэмжээ байгааг тогтоож байсан түүхтэй. Жишээ нь АНУ-ын Дээд шүүх эрүү шүүлт тулгасан хэргийг авч хэлэлцэх явцад АНУ нь Эрүү шүүлтийн эсрэг конвенцийг соёрхон батлаагүй болон дотоодын хуулиар уг харилцааг зохицуулаагүй байсан тул НҮБ-ын Ерөнхийн Ассамблейн баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хэрэглэж байсан юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь олон улсын гэрээ биш олон улсын байгууллагаас баталсан баримт бичгийн хувьд НҮБ-ын Дүрмийн 38 дугаар зүйлд зааснаар зөвлөмжийн шинжтэй юм. Энэ хэрэгт АНУ-ын шүүх нь тухайн маргаантай асуудлыг шийдвэрлэхэд хэрэглэгдэх эрх зүйн хэм хэмжээ байхгүй нөхцөлд олон улсын байгууллагаас гаргасан баримт бичгийг үндэслэж заншлын хэм хэмжээ тогтоосон¹⁷ буюу *opinio juris* гаргасан байна гэж судлаачид үзсэн.

Олон улсын заншлын хэм хэмжээг хүлээн зөвшөөрөхөө илэрхийлэх

Дараагийн нэг асуудал нь улс нь олон улсын заншлыг дагаж мөрдөхөө хэрхэн хүлээн зөвшөөрөх юм. Хэрэв олон улсын гэрээнд улс гарын үсэг зурах, соёрхон батлах зэрэг аргаар гэрээг дагаж мөрддөг бол олон улсын заншлыг дагаж мөрдөхөө хэрхэн илэрхийлэх юм бэ. НҮБ-ын Дүрмээр батлагдсан олон улсын эрх зүйн үндсэн зарчмын нэг нь олон улсын үүргээ шударгаар сайн дураар биелүүлэх буюу *pacta sunt servanda* байдаг нь олон улсын заншлын хэм хэмжээг хэрхэн улс дагаж мөрдөх талаар маргааныг өрнүүлсэн юм. Дотоодын эрх зүйн хэм хэмжээг сахин биелүүлэхэд албадлагын арга хэмжээ хэрэглэгддэг бол олон улсын эрх зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх эсэхээ улс өөрөө сайн дураараа шийддэг онцлогтой. Энэ ч утгаараа олон улсын гэрээнд нэгдэн орохыг нь албадахгүй байдаг. Тэгэхээр энэ зарчим мөн адил олон улсын заншлын хувьд адил үйлчлэх ёстой. Хэдий олон улсын заншлыг дагаж мөрдөхөө улс олон улсын гэрээтэй адил формал хэлбэржүүлсэн аргаар илэрхийлдэггүй ч олон улсын заншлыг улс дагаж мөрдөх илэрхийллээ практик, өөрийн үйлдлээр харуулж болох юм. НҮБ-ын шүүхэд **Норвегийн нутаг дэвсгэрийн ус болон загасчлалтай холбоотой хэргийг**¹⁸ авч хянан хэлэлцэх явцад олон улсын заншлын хууль зүйн хүчин чадлын талаар дүгнэлт гаргаж олон улсын эрх зүйн хөгжилд хувь нэмэр оруулсан юм. Олон улсын шүүхийн дагуу олон улсын заншил нь эрх зүйн хэм хэмжээ болох

¹⁷ Bruno V. Bitker, “Application of the United Nations’ Universal Declaration of Human Rights within the United States”, *DePaul Law Review*, 21, 1972, 337.

¹⁸ *Anglo-Norwegian Fisheries Case (United Kingdom v. Norway)*, *Judgment*, I.C.J. Reports 1951.

болон холбогдох улсад заавал дагаж мөрдөгдөх шинжтэй болохын тулд давтагдсан үйлдэл байхаас гадна нийтээр хүлээн зөвшөөрөгдөх ёстой юм. Нийтээр хүлээн зөвшөөрөгдөх гэдэгт олон улс эсхүл холбогдох хэд хэдэн улс хүлээн зөвшөөрч дагаж мөрдөхөөс гадна тухайн заншлын хэм хэмжээг эсэргүүцээгүй байх ёстой юм. Энэ шаардлагыг мөн Олон улсын шүүх *Колумб ба Перугийн улс төрийн орогнолын тухай хэрэгт*¹⁹ гаргаж ирсэн юм.

Дээрх болон судлаачдын бүтээлийг үндэслэхэд олон улсын заншил нь гурван үндсэн хэлбэрт илэрхийлэгддэг. Эхний хэлбэр нь улс орнуудын практикаар илэрхийлэгдэж болох бичигдээгүй заншил, хоёр дахь хэлбэр нь олон улсын байгууллагын тогтоол шийдвэрийг төрийн захиргааны болон бусад байгууллага практикт хэрэглэх, гуравдугаарт олон улсын шүүхээр заншлын хэм хэмжээг хэрэглэж *opinio juris* тогтоох байдлаар хэрэглэх хэлбэр тус тус байж болно гэжээ. Олон улсын заншлын хэм хэмжээ илэрхийлэгдэх хэлбэр өөрчлөн хувьсаж олон төрлийн болж байгаа нь олон улсын эрх зүйн зохицуулалтын хүрээ нэмэгдэх болсонтой холбоотой гэж үзэж болох юм.

3. Олон улсын заншлын хэм хэмжээ нь үр нөлөөтэй эрх зүйн хэм хэмжээний стандарт тогтоох болсон

Дэлхийн хоёрдугаар дайны олон улсын эрх зүй нь зөвхөн улс хоорондын харилцааг зохицуулах төдийгүй хүн төрөлхтөний сайн сайхны төлөө улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын эрх зүйн хэм хэмжээг тогтоох агуулгатай болж эхэлсэн. Тухайлбал, НҮБ-ын Дүрмийн оршил хэсэгт НҮБ-ын гишүүн орнууд энх тайвныг тогтоох, нийгмийн хөгжлийн дэвшлийг хөхиүлэн дэмжих, амьдралын нөхцөлийг сайжруулахын төлөө хамтран ажиллах болно гэж заасан юм. НҮБ-ын дүрэм батлагдсанаар хүн төрөлхтөний сайн сайхны төлөө улс орнууд хамтран ажиллаж, олон тооны олон улсын байгууллага, гэрээ байгуулсан билээ. Тухайлбал хүний эрх, эдийн засаг, хүрээлэн буй орчин, гэмт хэрэгтэй тэмцэх талаа болон агаар, сансар, далайн салбарт олон гэрээ байгуулагдсан.

Гэвч зарим салбар тухайлбал олон улсын тээвэр, худалдаа, хөрөнгө оруулалт, банк, нягтлан бодох зэрэг эдийн засгийн салбарын асуудлаар олон улсын гэрээ байгуулагдаагүй тул энэ салбарт сүүлийн жилүүдэд заншлын хэм хэмжээ чухал үүрэг гүйцэтгээд байгаа. Жишээ нь хөрөнгө оруулалтын талаар маргаан шийдвэрлэхэд Олон улсын арбитр холбогдох хөрөнгө оруулалтын хоёр талт гэрээг үндэслэхийн зэрэгцээ олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх нь

¹⁹ *Asylum Case (Colombia v. Peru)*, Judgment, I.C.J. Reports 1951.

элбэг болоод байгаа. Үүнтэй холбогдуулан олон улсын заншлын хэм хэмжээ илэрхийлэгдэх хэлбэр ч нэмэгдэх болсон юм. Олон улсын эрх зүйн зохицуулалтын хийдлийг нөхөхөд олон улсын байгууллагаас боловсруулсан зөвлөмж, стандарт чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд үүний нэг жишээ нь Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын байгууллага (англ.ОECD) юм.

1960-д онд байгуулагдсан Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын байгууллага нь эдийн засаг, нийгмийн зохицуулалтын олон улсын стандарт хэм хэмжээ боловсруулах, сайн засаглал, үр өгөөжтэй эдийн засгийн тогтолцоог бий болгох зорилготой ажилладаг юм. Энэ байгууллагын хүрээнд боловсруулсан олон баримт бичгийг сайн засаглал, банк санхүү, татвар тооцоолол, нягтлан бодох, шударга бус өрсөлдөөний үйл ажиллагааг тогтооход хэрэглэдэг болоод байна. Хэдий өнөө үед олон салбарт олон улсын гэрээ байгуулж олон улсын эрх зүйн стандарт тогтоосон ч олон салбар зохицуулагдаагүй хэвээр байгаа юм. Тухайлбал уламжлалт ёсоор дотоодын эрх зүйн асуудалд тооцогдож байсан шударга өрсөлдөөн, татвар, нягтан бүртгэл, банкны үйл ажиллагаа, даатгалын салбарт олон гэрээний хэм хэмжээ дутмаг, мөн дотоодын эрх зүйгээр нарийн зохицуулаагүй нөхцөлд Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын байгууллагын боловсруулсан зөвлөмж, аргачлалыг олон орнууд хэрэглэж байна.

НҮБ-ын хүрээнд мөн эрх зүйн стандарт тогтоох талаар олон ажил хийж салбар салбарын эрх зүйн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулсаар байна. Жишээ нь НҮБ-ын төрөлжсөн байгууллагын хүрээнд олон улсын гэрээний төслийг боловсруулсан төдийгүй загвар хууль, худалдаа, бизнесийн олон аргачлалыг боловсруулсан юм. Жишээ нь НҮБ-ын олон улсын худалдааны эрх зүйн комисс нь Арбитрын загвар хууль²⁰, НҮБ-ын Мансууруулах бодис ба гэмт хэргийн судалгааны газраас Зохион байгуулалттай гэмт хэргийн загвар хууль, Хүний хулгайтай тэмцэх загвар хууль, Терроризмын эсрэг загвар хууль бэлтгэсэн²¹. НҮБ-ын Худалдаа ба хөгжлийн олон улсын бага хурлын хүрээнд Өрсөлдөөний зарчим ба хэрэглэгчийн эрх²² гэсэн зөвлөмжийг боловсруулсан зэрэг жишээ нь өнөө үед олон улсын байгууллагууд хүн төрөлхтөний сайн сайхны төлөө үр дүнтэй ба үр нөлөөтэй эрх зүйн тогтолцоог бий болгоход өөрийн хувь нэмрээ оруулсаар ирсэн юм.

Дээрх хэд хэдэн жишээг харахад олон улсын заншил нь уламжлалт

²⁰ https://uncitral.un.org/en/texts/arbitration/modellaw/commercial_arbitration, (Сүүлд үзсэн: 2026.03.06).

²¹ <https://www.unodc.org/unodc/en/commissions/CND/index.html>, (Сүүлд үзсэн: 2026.03.06).

²² <https://www.oecd.org/competition/>, (Сүүлд үзсэн: 2026.03.06).

ойлголтоос хальж зөвхөн улс хоорондын харилцаанд баримтлагддаг бичигдээгүй хууль хэм хэмжээ байхаа больж бичигдсэн хэлбэртэй нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ болж хувираад энэ нь олон улсын үндсэн эх сурвалжаас бусад баримт бичигт тусгагддаг юм байна. Ардчилсан бөгөөд зах зээлийн нийгэмд шилжээд удаагүй манай улсын хувьд эрх зүйн зохицуулалтаа хөгжүүлэхэд олон улсын стандарт болон олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж, загварыг ашиглах нь бусад улстай харьцуулахад илүү богино хугацаанд үр дүнтэй бөгөөд үр нөлөөтэй эрх зүйн зохицуулалттай болох боломжтой юм.

Монгол улсад олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх шаардлага, практик ба холбогдох эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг авч үзэх нь цаашдын чиг хандлагыг тодорхойлоход ач холбогдолтой юм.

4. Монгол улсын хуульд олон улсын заншлыг хэрэглэх талаар зохицуулсан байдал

Монгол улсад иргэний шүүх, захиргааны шүүх болон арбитраж олон улсын заншлыг хэм хэмжээг хэрэглэх мөн төрийн захиргааны зарим байгууллага холбогдох хуулийг хэрэгжүүлэхдээ олон улсын стандарт хэм хэмжээ, зөвлөмж, аргачлалыг баримтлах чиг хандлага ажиглагдах болсон. Олон улсын хэмжээнд Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын байгууллагын шударга бус өрсөлдөөний үйл ажиллагаа явуулсан эсхүл давамгайл байдлаар хууль бусаар ашигласан байдлыг тогтоох талаар зааварчилгаа боловсруулсан зөвлөмжийг²³ дотоодын хэмжээнд улс орнууд ашиглаж байна. Мөн худалдааны арбитраж олон улсын хэмжээнд бараа худалдах худалдан авах, тээвэрлэхтэй холбоотой харилцаанд олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэж ирсэн. Монгол улсын Захиргааны шүүхэд татварын маргаан, гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн татварыг тооцох аргачлал, үнийн судалгаанд мөн олон улсын стандарт хэрэглэх магадлал байна.

Дээрх нөхцөл байдал нь Монгол улсад олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээг хэрэглэх эрх зүйн үндэс, хэрэгцээ шаардлагыг судлан авч үзэхийг нөхцөлдүүж байна.

1992 онд Ардчилсан шинэ Үндсэн хууль²⁴ батлагдсанаар дэлхийн олон улс орнуудтай харилцаа тогтоож, олон улсын эрх зүйн бүтээлцэх үйл ажиллагаанд олон улсын гэрээ байгуулах хэлбэрээр оролцох болсон төдийгүй, олон улсын эрх зүйн стандартыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх тал дээр анхаарч эхэлсэн.

²³ <https://www.oecd.org/competition/>, (Сүүлд үзсэн: 2026.03.06).

²⁴ Монгол Улсын Үндсэн хууль (1992), *өмнөх ишлэл 4*.

Монгол улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай хууль нь олон улсын гэрээг дагаж мөрдөх болон олон улсын гэрээг байгуулах, хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтын үндэс болдог. Монгол улс 1969 онд батлагдсан Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенцийг 1988 онд соёрхон баталсан бөгөөд тус гэрээний 27 дугаар зүйлд “олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнийг дотоодын хуульд өөрөөр заасан гэсэн үндэслэлээр зөвтгөхгүй” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт «олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна» гэж заасан. Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгээс 4 дэх хэсэг нь олон улсын гэрээний талаар зохицуулсан бөгөөд олон улсын заншлын хэм хэмжээг зохицуулсан зүйлийг агуулаагүй юм. Олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрхэн дагаж мөрдөх талаар үндэс болсон Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх талаар зохицуулаагүй нь практикт асуудал үүсгэх эсрэдэлтэй юм.

Энэхүү өгүүллийн өмнөх хэсэгт авч үзсэнээр олон улсын заншлын хэм хэмжээ нь хүчин төгөлдөр болоогүй олон улсын гэрээ, олон улсын байгууллагаас гаргасан шийдвэр, тогтоол хэлбэрээр илэрхийлэгдсэн байж болно. Олон улсын маргаан шийдвэрлэх байгууллагууд олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх тохиолдол олон гардаг. Монгол улсад мөн олон улсын гэрээ, хууль холбогдох зохицуулалтын хэм хэмжээ агуулагдаагүй нөхцөлд олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж стандартыг үндэслэх боломжтой болоод байна. Жишээ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Татварын ерөнхий хуулийн²⁵ «Олон улсын татварын хамтын ажиллагаа, татвараас зайлсхийх ерөнхий дүрэм» гэсэн 4 дүгээр бүлгийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: «Татварын хяналт шалгалтын үеэр доор дурдсан нөхцөл бүрдсэн нь тогтоогдсон боловч хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэн татварыг нөхөн ногдуулах боломжгүй бол Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх эрхтэй байна» гэж заасан байна. Татварын ерөнхий хуулийн энэхүү зохицуулалт нь Монгол улсад мөн адил төрийн байгууллагад татвар тооцоход олон улсын байгууллагаас гаргасан стандарт зөвлөмжийг хэрэглэх болсон төдийгүй хуульдаа нэвтрүүлэн зохицуулсан байдлыг харуулж буй тод жишээ юм.

Олон улсын заншлын хэм хэмжээг эдийн засгийн салбарын харилцааг зохицуулахад хэрэглэх хандлага байгаа боловч эдгээр хэм хэмжээг үндэслэж маргаан шийдвэрлэх боломж ба холбогдох эрх зүйн

²⁵ Татварын ерөнхий хууль (2019), 16 дугаар зүйл 16.1, *Төрийн мэдээлэл*, 2019, №22, (Улаанбаатар: 2019).

зохицуулалт манай улсад байгаа эсэх нь том асуулт юм. Шүүхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт «Шүүх хүчин төгөлдөр болсон албан ёсоор нийтлэгдсэн, Монгол улсын олон улсын гэрээг хэрэглэнэ» гэж заасан боловч олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх талаар огт зохицуулаагүй байна. Монгол улсын Үндсэн хуульд мөн олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэж болох талаар заасан зохицуулалт алга. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ... **олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ ба зарчим** гэдэгт олон улсын заншлын хэм хэмжээг багтаан ойлгож болох юм.

Дэлхийн олон оронд олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ гэдэгт олон улсын заншлыг ойлгох хандлага байна. Жишээ нь ОХУ-ын Дээд шүүхийн бүх нийтийн хурлаар баталсан «ОХУ-ын нийтлэг харьяалалтай шүүхэд олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим хэм хэмжээ, олон улсын гэрээг хэрэглэх тухай» тогтоолын²⁶ 1 дэх заалтанд ОХУ-ын Үндсэн хуульд заасан **олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ** зарчим гэдэгт олон улсын хэмжээнд баримталдаг бөгөөд нийтээр хууль зүйн шинжийг нь хүлээн зөвшөөрсөн нийтлэг зан үйлийг ойлгоно» гэж заасан байдаг. Евразийн Эдийн засгийн холбооны шүүхэд мөн энэ байр суурийг баримталдаг гэж судлаач А.В.Пронин тэмдэглэсэн байв²⁷. Евразийн эдийн засгийн холбооны Шүүхийн дүрмийн 50 дугаар зүйлд тус шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ олон улсын гэрээ болон олон улсын заншлыг хэрэглэнэ гэж мөн заасан байв.

НҮБ-ын олон улсын эрх зүйн Комисс мөн энэ талаар судалгаа хийж 2012 оноос эхлэн үйл ажиллагааны хөтөлбөртөө²⁸ олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээг тогтоох, илрүүлэх ажлыг тусгасан бөгөөд олон улсын заншлын хэм хэмжээг тогтооход нэгд улс орнуудын практик байгаа эсэх, хоёрт холбогдох улс орнууд түүний хууль зүйн хүчин чадлыг зөвшөөрч, дагаж мөрдөж байгаа эсэх шалгууруудыг авч үзэх ёстой гэжээ. Олон улсын эрх зүйн комисс мөн дотоодын шүүх олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээг тогтооход оролцож буй байдлыг судлан авч үзсэн байв. Олон улсын эрх зүйн комисс дотоодын шүүхэд олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэж байгаа нь тухайн заншлыг хууль зүйн шинжтэй болгодог гэж дүгнэж авч үзсэн нь мөн үндэслэлтэй байж болох юм. НҮБ-ын Олон улсын

²⁶ Постановление Пленума Верховного Суда РФ от 10 октября 2003 г. № 5 “О применении судами общей юрисдикции общепризнанных принципов и норм международного права и международных договоров Российской Федерации”.

²⁷ А. В. Пронин, *Статут Суда Евразийского экономического союза*, (2017), <http://courteurasian.org/doc-14063>, (Сүүлд үзсэн: 2026.03.06).

²⁸ International Law Commission, *Identification of Customary International Law*, 2012, http://legal.un.org/ilc/guide/1_13.shtml, (Сүүлд үзсэн: 2026.03.06).

шүүх мөн хэргийг хянан шийдвэрлэж, дүгнэлт гаргахдаа дотоодын шүүхэд холбогдох заншлыг хэрэглэж байгаа нь түүнд хууль зүйн шинжтэй буюу *opinio juris* олгож байгаагийн жишээ мөн гэдэгтэй санал нэгтэй байна.

Монгол Улсын 2009 оны Дээд шүүхийн тогтоолын 1 дэх заалтанд “**Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ** гэдгийг олон улсын хамтын нийгэмлэгээс тогтоож, хүлээн зөвшөөрсөн, хууль зүйн хувьд заавал даган биелэгдэх хүчин чадалтай зан үйлийн дүрэм гэж ойлгоно” гэж заасан байдаг. Тус тогтоолд илүү олон улсын гэрээг Монгол улсад хэрэглэх талаар тайлбарласан боловч заншлын хэм хэмжээг хэрэглэх талаар заагаагүй. Гэхдээ Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг тайлбарлахыг зорьсон бөгөөд тайлбарын агуулгыг авч үзэхэд олон улсын заншлын хэм хэмжээний зарим шинжийг агуулсан гэж дүгнэгдэхээр байна. Дээд шүүхийн холбогдох тайлбарыг авч үзвэл Монгол Улсад Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн агуулгыг олон улсын заншилтай холбон тайлбарлаж, хууль хэрэглээний үндэс байна гэж хэлж болох юм.

Монгол улсын холбогдох хуульд заншлын хэм хэмжээг хэрэглэж болох талаар цөөн хэдэн зохицуулалт байна. Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээ байхгүй бол тухайн харилцааг иргэний эрх зүйн агуулга, зарчим, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахуны хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулна²⁹” гэж заасан. Мөн хуулийн 540 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шаардлагатай бол шүүх иргэний хэрэг, маргаан шийдвэрлэх буюу иргэний эрх зүйн бусад харилцааг зохицуулахад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд харшлаагүй гадаад улсын хууль, эрх зүйн болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг хэрэглэж болно” гэж заасан нь иргэний эрх зүйн харилцаанд олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх эрх зүйн үндэс бүрдсэн байна.

Иргэний харилцаанд олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх нь илүү тохиолдох бөгөөд ялангуяа энэ нь улс хоорондын худалдаа, тээвэрлэлтийн харилцаанд хамаарч болно. Гадаад орнуудын ба Монгол улсын Арбитрын практикт мөн олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэсэн тохиолдол бий гэж дээр дурдсан. Тухайлбал улс хооронд бараа худалдах худалдан авах зохицуулалтанд талууд холбогдох харилцаагаа гэрээгээр зохицуулаагүй, эсвэл нийтээр хүлээн зөвшөөрсөн тогтсон заншил практикийг хэрэглэж

²⁹ Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоол (2009).

байсан. Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт «Арбитрын бүрэлдэхүүн талуудын хооронд байгуулсан гэрээний нөхцөлд үндэслэн тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны зан заншлыг харгалзан маргааныг шийдвэрлэнэ»³⁰ гэж заасан нь мөн арбитрын шүүхэд хамаарах хэрэгт заншлын хэм хэмжээг хэрэглэгдэх боломжтойг харуулсан юм.

Монгол улсад захиргааны байгууллагад захиргааны акт тогтоох болон үүнтэй холбогдуулан захиргааны хэргийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэхдээ олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх нөхцөл үүссэн байна. Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгад³¹ олон улсын байгууллагаас боловсруулсан дүрмийг татвар ногдуулахад ашиглах талаар зааж өгсөн байдал мөн бусад захиргааны байгууллагад энэ практик тогтох магадлалтай тул олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх зохицуулалтыг бий болгох нь Үндсэн хуулийн 10 дугаар зүйл болон бусад үндэсний эрх ашиг, аюулгүй байдлыг хамгаалах талаасаа ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд Монгол улсад олон улсын байгууллага болон бусад олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй олон нийтийн байгууллагаас боловсруулан гаргасан зөвлөмж, стандартыг дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэх, өргөнөөр ашиглах байдал нэмэгдэх хандлага илт байна. Ялангуяа эдийн засгийн харилцааг зохицуулахад олон улсын байгууллага нь олон төрлийн зөвлөмж, шаардлага тавьдаг болсон. Жишээ нь Терроризмыг санхүүжүүлэх болон мөнгө угаахын эсрэг олон улсын конвенцийн³² дагуу болон FATF буюу санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (орч.) нь зөвлөмж боловсруулж (FATF standards) гишүүн орнуудаас эдгээр зөвлөмжийг хууль тогтоомждоо тусгахыг шаардаж байгаа нь мөн л олон улсын эрх зүйн стандарт тогтоож байгаагийн жишээ юм.

Шударга өрсөлдөөний байгууллагууд аж ахуйн нэгж нь шударга бус өрсөлдөөний үйл ажиллагаа явуулсан эсэхийг тогтоох, давамгайл байдлаа хууль бусаар ашигласан, давамгайл байдалтай эсэх мөн картелийн үйл ажиллагааг тогтооход эдийн засгийн олон аргачлал³³ хэрэглэдэг. Гэтэл Монгол улсад зах зээлийн эдийн засгийн дэглэмд шилжээд удаагүй нөхцөлд эдгээр аргачлалыг боловсруулаагүй байх, холбогдох журам нь байхгүй, хуулиар зохицуулаагүй үед олон улсын байгууллагын зөвлөмжийг ашиглахыг үгүйсгэхгүй юм. Эдийн засгийн

³⁰ Иргэний хууль (2002), 4 дүгээр зүйл 2 дахь хэсэг, 540 дүгээр зүйл 1 дэх хэсэг.

³¹ Арбитрын тухай хууль (2017), 40 дүгээр зүйл 5 дахь хэсэг.

³² Терроризмыг санхүүжүүлэх болон мөнгө угаахын эсрэг олон улсын конвенц (1999), (Улаанбаатар: 2004).

³³ OECD, Competition Assessment Toolkit, <https://www.oecd.org/daf/competition/46193173.pdf>, (Сүүлд үзсэн: 2026.03.06).

хамтын ажиллагааны олон улсын байгууллагын гишүүн орнууд эдгээр аргачлалыг ашиглаж, зарим нь эдгээрт нийцүүлэн дотоодын дүрэм журам боловсруулсан байх жишээтэй. Өөр нэг жишээ нь олон улсын төлбөр тооцоо, банкны харилцаанд хэрэглэгдэх түгээмэл олон улсын гэрээ байхгүй бөгөөд мөн л энэ харилцаанд олон улсын заншлын хэм хэмжээ чухал үүрэг гүйцэтгэж байна. Банкны үйл ажиллагаанд хяналт тавих олон улсын Базелийн хороо мөн олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй банкуудад банкны стандарт тогтоож, гишүүн орнууддаа эдгээрийг хэрэгжүүлэхийг шаарддаг юм.

Олон улсын эдийн засгийн харилцаанд улам бүр идэвхтэй оролцож байгаа манай улсын хувьд олон улсын заншлын хэм хэмжээг хэрхэн хэрэглэх талаар зохицуулах шаардлагатай буйг дээрх жишээ харуулж байна. Эдийн засгийн харилцаа нь илүү түрүүлэн хөгжиж буй өнөө үед эрх зүйн зохицуулалтаа энэхүү өөрчлөлтөнд нийцүүлэн бий болгох нь чухал юм. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлээр олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим хэм хэмжээг хэрэглэхийг зөвшөөрсөн гэж үзсэн ч энэхүү хэм хэмжээ нь ямар агуулгатай байх юм, Монгол улсын язгуур эрх ашиг, үндэсний аюулгүй байдалд нийцээгүй бол яах вэ гэдэг асуулт мэдээжийн хэрэг тавигдана.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээг сайн дурын үндсэн дээр шударгаар биелүүлнэ гэсэн НҮБ-ын үндсэн зарчмын нэг болох зарчим өнөөдөр практикт хэрэгжиж байгаа юу гэсэн асуулт ч тавигдана. Хэрэв олон улсын гэрээг улс нь дагаж мөрдөхөө гэрээнд нэгдэн орох соёрхон батлах аргаар илэрхийлдэг бол олон улсын заншлын хувьд энэ нь хэрэгжих боломжтой юу. Олон улсын заншил гэдэгт нийтээр хүлээн зөвшөөрсөн байх ба улс түүнийг дагаж мөрдөхгүй байх талаар эсэргүүцээгүй л бол хууль зүйн хүчин чадалтай болох агуулгатай гэж олон улсын эрдэмтэн судлаачид үзээд байна. Тэгвэл манай улсын хувьд олон улсын заншил илэрхийлэгдэх нэг хэлбэр болоод байгаа олон улсын байгууллагаас боловсруулсан зөвлөмжийг дагаж мөрдөх үүргийг тухайн олон улсын байгууллагын үүсгэн байгуулсан олон улсын гэрээний дагуу гишүүн орны хувьд үүрэг хүлээж байгаа нь олон улсын заншлыг эсэргүүцэхгүй байгаа гэж ч ойлгогдохоор байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд Монгол улсын Үндсэн хууль, Монгол улс олон улсын гэрээг, бусад хууль тогтоомжийг хэрэглэнэ гэж заасан бөгөөд олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх талаар зохицуулаагүй. Гэтэл Татварын хуулийн шинэчилсэн найруулгыг үндэслэвэл Захиргааны шүүхэд олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх шаардлага гарахыг үгүйсгэхгүй юм.

Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн үг утгыг авч үзэхэд Монгол

улс гадаад бодлого хэрэгжүүлэхдээ олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим хэм хэмжээг хэрэглэнэ, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 2-4 дэх хэсэгт олон улсын гэрээний талаар зохицуулсан тул олон улсын заншлын хэм хэмжээ үндэсний эрх зүйн тогтолцоонд ямар үүрэгтэй байх талаар зохицуулаагүй үлдсэн байна гэж дүгнэгдэхээр байна. Эрүүгийн эрх зүйн салбарт заншлын хэм хэмжээ хэрэглэгдэхгүйг бүгд мэдэх ч иргэний эрх болон захиргааны эрх зүйд олон улсын заншлын хэм хэмжээ хэрэглэгдэх хандлагатай өнөө үед энэ салбарын зохицуулалт хийгдэж, Үндсэн хуульд харшлахгүй хэм хэмжээг хэрэглэх эрх зүйн үндэс тогтоох нь зүй ёсны юм.

Дүгнэлт

Олон улсын эрх зүйн зохицуулах зүйл нь улс хоорондын харилцаа төдийгүй дотоодын эрх зүйн хэм хэмжээний загвар олон улсын эрх зүйн стандарт тогтоох болж илүү өргөн хүрээний харилцааг хамрах болсон юм. Олон улсын олон байгууллагууд дотоодын эрх зүйн үр нөлөөтэй зохицуулалтыг бий болгох зорилгоор зөвлөмж, стандарт боловсруулах ажлыг идэвхтэй гүйцэтгэх болсон. Улс орнууд эдгээр зөвлөмж стандартыг үндэсний хэмжээнд хэрэглэх байдал дэлхийн орнуудад нэмэгдэж, Монгол улс мөн олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх хандлага гарч ирч байна. Монгол улсын Иргэний хууль, Захиргааны эрх зүйн салбарын зарим хуульд олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэж болох талаар үзэл санаа тусгагдсан байна. Үндсэн хуульд олон улсын гэрээний дотоодын эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурийг тогтоосон ч олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх талаар огт зохицуулаагүй үлдээсэн байна. Бусад хуульд мөн олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэх талаар зохицуулахгүй, олон улсын гэрээний давамгайл байдлыг илүү тодорхойлж зохицуулсан.

Олон улсын заншлын хэм хэмжээ илэрхийлэгдэх хэлбэр улам бүр нэмэгдэж байгаа ба олон улсын эрх зүйн хүрээнд энэ асуудал нь нэг мөр шийдэгдээгүй үед манай улсад олон улсын заншлын хэм хэмжээг тодорхойлон тогтоож, өөрийн улсын шүүхийн болон захиргааны байгууллагын хэрхэн хэрэглэх талаар зохицуулах шаардлага байгаа юм байна гэж дүгнэгдэж байна.

[Ном зүй]

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл, тусгай дугаар 1, Улаанбаатар хот, 1992 он.

Anglo-Norwegian Fisheries Case (United Kingdom v. Norway), I.C.J, 1951.

Asylum Case (Colombia v. Peru), I.C.J, 1951.

Basic Law for the Federal Republic of Germany, <https://www.bundesregierung.de/breg-en/chancellor/basic-law-470510>, 1949.

Bitker Bruno V, “Application of the United Nations’ Universal Declaration of Human Rights within the United States,” DePaul Law Review, 21, 1972.

Brownlie Ian, Principles of Public International Law, Oxford University Press, 2008.

Constitution of Japan, <http://www.japaneselawtranslation.go.jp/law/>, 1946.

Evans Malcolm D. (Ed.), International Law, Oxford University Press, 2003.

Fidler David P, “International Law and Infectious Diseases”, Evidence of Customary Law, 2001.

Hirsch Moshe, “Sources of International Investment Law”, International Law Forum, The Hebrew University of Israel, 2011.

International Chamber of Commerce, Incoterms 2020 Rules, Paris: ICC, 2020.

North Sea Continental Shelf (Federal Republic of Germany v. Denmark; Federal Republic of Germany v. Netherlands), Judgment, I.C.J. Reports, 1969.

Organisation for Economic Co-operation and Development (OECD), Guidelines and Recommendations, Paris, 2020 .

Schachter Oscar, “International Law in Theory and Practice,” Recueil des Cours, vol. 178 (1982-V), 1982 он.

Schwebel Stephen M, “The Effect of Resolutions of the U.N. General Assembly on Customary International Law,” Proceedings of the American Society of International Law, 1979.

Trachtman Joel P, “The Obsolescence of International Customary Law,” SSRN Research Database, 2014.

United Nations, Statute of the International Court of Justice, 1945.

United Nations, Vienna Convention on the Law of Treaties, “Төрийн мэдээлэл,” тусгай дугаар 2, Улаанбаатар хот, 1969 он

[Abstract]

**Theoretical and Practical Issues on Recognition of
International Customary Law in Mongolian Legal System**

Uyanga Myagmar

Doctor of Laws (Ph.D.).

*Associate Professor at the Public Law Department,
School of Law, National University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia*

This article examines how international customary norms are recognized and applied within the legal system of Mongolia, from both theoretical and practical perspectives. The objective is to define the legal status of customary international law and assess the need for its incorporation into national legislation. The study finds that although Mongolia lacks explicit constitutional provisions on customary international law, certain laws such as the Civil Code and the Law on Arbitration, provide a basis for its application. The article concludes that it is necessary to clearly define customary norms and integrate them into the national legal framework to ensure legal clarity and consistency.

[Keywords]

International customs, International Law, Constitution, Legal sources, use of Customs in courts, Economic Law, Taxes, Investment, Trade, Courts, Economic Relations.